ИХ НАЯД АУДИТ
НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙНХЭНАЛТЫН ХАРААТ БУС ИТГЭМЖЛЭГДСЭН ХӨНДЛӨНГИЙН БАЙГУУЛЛАГА
Улаанбаатар хот, СБД, 8-р хороо, River Castle Business Apartment 924 тоот,
Утас: +976 99077062, 9666-4168
И-мэйл: audit@ikhnayad.mn

2026.02.10 № СТА-ББСБ-25/101

“КРЕДИТЕХ СТМ ББСБ” ХХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

ӨӨРЧЛӨЛТГҮЙ ДҮГНЭЛТ

Аудитын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу “КРЕДИТЕХ СТМ ББСБ” ХХК -ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүү байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, санхүүгийн тайлангийн тодруулгуудад аудит хийлээ.

“КРЕДИТЕХ СТМ ББСБ” ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол улсын холбогдох хууль, журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлагнал, нягтлан бодох бүртгэл, бүртгэлийн суурь, бодлогын өөрчлөлтөд тайлант хугацаанд өөрчлөлт ороогүй болно.

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

ИХ НАЯД АУДИТ
ХУУДАСНЫ ДУГААР 2

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

“ИХ НАЯД АУДИТ” ХХК

ЗАХИРАЛ ..... Х.АРИУНЗУЛ

Улаанбаатар хот, Монгол улс

Огноо: 2026 оны **02** сарын **10**

ИНС ИХ НАЯД АУДИТ
ХУУДАСНЫ ДУГААР 3

"КРЕДИТЕХ СТМ ББСБ" ХХК

БАЛАНС
2025 он 12 сарын 31-ны үлдэгдэл

	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
ХӨРӨНГӨ		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	647,557,959.52	1,298,857,504.75
Зээл	9,990,491,204.34	13,352,764,210.24
Факторингийн тооцооны авлага		
Үүсмэл санхүүгийн хөрөнгө		
Хөрөнгө оруулалт		
Бусад санхүүгийн хөрөнгө		
Санхүүгийн хөрөнгийн дүн	**10,638,049,163.86**	**14,651,621,714.99**
Татвар, НДШ-ийн авлага		
Үндсэн хөрөнгө	15,983,949.01	39,959,886.12
Биет бус хөрөнгө	-	-
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	-	-
Бусад санхүүгийн бус хөрөнгө	340,670,961.16	21,265,435.90
Санхүүгийн бус хөрөнгийн дүн	**356,654,910.17**	**61,225,322.02**
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	**10,994,704,074.03**	**14,712,847,037.01**
ӨР ТӨЛБӨР		
Итгэлцлийн үйлчилгээний эх үүсвэр	2,225,911,024.00	2,165,122,821.88
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	3,010,137,797.21	1,505,326,027.39
Бусад эх үүсвэр	1,770,544,520.55	2,335,492,465.75
Үүсмэл санхүүгийн өр төлбөр	-	-
Бусад санхүүгийн өр төлбөр	-	-
Хоёрдогч өглөг	-	-
Давуу эрхийн хувьцаа (өр төлбөр)	-	-
Санхүүгийн өр төлбөрийн дүн	**7,006,593,341.76**	**6,005,941,315.02**
Татвар, НДШ-ийн өр төлбөр	62,837,790.72	112,339,692.92
Нөөц /Болзошгүй өр төлбөр /	-	-
Хойшлогдсон татварын өр төлбөр	-	-
Бусад санхүүгийн бус өр төлбөр	535,879.52	42,180,060.80
Санхүүгийн бус өр төлбөрийн дүн	**63,373,670.24**	**154,519,753.72**
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	**7,069,967,012.00**	**6,160,461,068.74**
Хувь нийлүүлсэн хөрөнгө	3,500,000,000.00	7,700,000,000.00
Өмчийн бусад хэсэг	-	27,500,000.00
Хуримтлагдсан ашиг, (алдагдал)	424,737,062.03	824,885,968.27
НИЙТ ӨМЧИЙН ДҮН	**3,924,737,062.03**	**8,552,385,968.27**
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨМЧИЙН ДҮН	**10,994,704,074.03**	**14,712,847,037.01**

- 0.00

ИНС ИХ НАЯД АУДИ
ХЯНАСАН ДУГААР 4